



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ДОТООД АУДИТЫН АЛБА

Нийслэлийн засаг захиргааны III байр,
Ж.Самбуугийн 16 дугаар гудамж,
4 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, 15170
Утас: (976) 7014 3050
Цахим шуудан: audit@chingeltei.gov.mn

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ГАЗАР
ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АЛБАНЫ
ДАРГА Ж.ТАМИР ТАНАА

2025.04.11 № 62
танай _____-ны № _____-т

Зөвлөмж хүргүүлэх тухай

Монгол улсын Сангийн сайдын 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн СХШХ/06 дугаартай удирдамж, дүүргийн Засаг даргын 2025 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 25/06 дугаар бүхий удирдамжуудын дагуу Чингэлтэй дүүргийн Газар зохион байгуулалтын албаны 2023, 2024 оны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийхэд дараах зөрчил, дутагдал илэрлээ. Үүнд:

- Газрын мэдээллийн нэгдсэн системд бүртгэлтэй хүчинтэй 13765 нэгж талбарын мэдээллээс 529 нэгж талбарын байршлын хаягийн мэдээллийг оруулаагүй, зарим нэгж талбарын хувийн хэргийн бүрдэл дутуу, 2024 оны архивласан баримтууд нь архивын стандартын шаардлага хангаагүй.
- Газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацаа дуусахаас 30 хоногийн өмнө сунгуулах хүсэлтээ гаргаагүй газрын хууль зөрчсөн 455 иргэн аж ахуйн нэгжийн газар эзэмших эрхийн гэрчилгээг сунгахдаа зөрчлийн тухай хуулийг хэрэгжүүлээгүй.
- Газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацаагаа сунгуулсан иргэн хуулийн этгээдийн эрхийн гэрчилгээ хүчингүй байх хугацааны газрын төлбөрийн ногдлыг хийгээгүй.
- 2023, 2024 оны газрын төлбөрийн ногдлыг дутуу ногдуулсан.
- Газрын төлбөрийн ногдуулалтыг нягтлан шалгаж татвар хураалтын эцсийн дүн болон тооцоог дүүргийн Татварын хэлтэс, Газар зохион байгуулалтын албатай тулган баталгаажуулалт хийгдээгүй, газрын асуудал хариуцсан байгууллагын газрын төлбөр төлөгчийн тоон мэдээлэл болон нэгж талбарын тоо ТНУС-ийн тоон мэдээлэл зөрүүтэй.
- 2023-2024 оны Чингэлтэй дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас баталсан тогтоолоор батлагдсан газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд газрын нэгж талбарын дугаарыг тусгаагүй байна.
- Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар шинээр газар эзэмших эрх авснаас хойш зориулалтын дагуу огт ашиглаагүй 1704 нэгж талбар бүхий 123.3 га газрын газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгоогүй.

Чингэлтэй дүүргийн Газар зохион байгуулалтын албанд хийсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг дахин гаргахгүй байхад анхаарч

ажиллахыг дараах **ЗӨВЛӨМЖ** хүргүүлж байна. Үүнд:

1. Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын даргын тушаалаар баталсан “Нэгж талбарын хувийн хэргийг хөтлөх журам”, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолоор баталсан “ Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”-ын 7.2.5, 7.2.6-д заасан шаардлагыг хэрэгжүүлэн ажиллах.

2. Монгол улсын газрын тухай хуулийн 37.1, 39.1.1 , Зөрчлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 10.1 заалтуудыг хэрэгжүүлэн ажиллах.

3. Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1, Газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4.5 заалтуудын хэрэгжилтийг хангаж ажиллах.

4. Газрын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.6 “ Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гэрээнд заасан зориулалтын дагуу тухайн газраа 2 жил дараалан ашиглаагүй тохиолдолд газар эзэмших гэрчилгээг хүчингүй болгоно” заалтыг хэрэгжүүлэн ажиллах.

5. Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас баталсан тогтоолоор батлагддаг газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд газрын нэгж талбарын дугаарыг тусгах.

6. Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1 " Хуулийн дагуу улс орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх", Газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4.5 " Газрын төлбөрийг зохих хууль тогтоомжийн дагуу тодорхойлж ногдуулах" заалтыг хэрэгжүүлэн ажиллах.

7. Татварын ерөнхий хуулийн 34 дүгээр зүйлийн 34.22." Газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага газрын төлбөр төлөгчийн, газраас авах үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар төлөгчийн бүртгэл, газрын төлбөрийн ногдуулалт, төлөлтийн болон газраас авах үл хөдлөх эд хөрөнгийн татвар ногдуулалттай холбоотой мэдээллийг тухай бүр гаргаж, татварын албатай харилцан мэдээлэл солилцоно" заалтыг хэрэгжүүлж улирал бүр татварын албатай тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулж байх.

Зөвлөмжийн дагуу зөрчил дутагдал арилгасан талаар 2025 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн дотор дүүргийн Дотоод аудитын албанд албан бичгээр хариу ирүүлэхийг мэдэгдье.

Тус албанаас зөвлөмжийн дагуу хийж хэрэгжүүлсэн ажилд 2025 оны 4 дүгээр улиралд хяналт шалгалтын ажлыг зохион байгуулан ажиллах болно.



Чингэлтэй дүүргийн засаг даргын дэргэдэх дотоод аудитын алба
Удирдлага
Дарга
Маам Хоролсүрэн
2025.04.11 14:59



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ДОТООД АУДИТЫН АЛБА**

Нийслэлийн засаг захиргааны III байр,
Ж.Самбуугийн 16 дугаар гудамж,
4 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, 15170
Утас: (976) 7014 3050
Цахим шуудан: audit@chingeltei.gov.mn

2025.03.12 № 49
танай _____-ны № _____-т

Зөвлөмж хүргүүлэх тухай

Манай алба нь Чингэлтэй дүүргийн Засаг даргын баталсан 2025 оны 25/01 удирдамжийн дагуу Чингэлтэй дүүргийн Тохижилт үйлчилгээ ХХК-ний 2023 оны 02 дугаар сарын 07-ний өдрийн 2023/01-32 тоот “Дүүргийн өмчийн арчлалт, хамгаалалт хариуцах ажлын гэрээ”, 2024 оны 03 дугаар сарын 12-ний өдрийн 2024/01-47 тоот “Дүүргийн өмчийн арчлалт, хамгаалалт хариуцах ажлын гэрээний нэмэлт гэрээ”-ний гэрээгээр хүлээсэн үүрэг хариуцлагын биелэлт, гүйцэтгэлийн санхүүжилтэд хяналт шалгалт хийлээ.

Тус хяналт шалгалтаар:

- 2023 онд Чингэлтэй дүүргийн Засаг даргын тамгын газартай байгуулсан гэрээний 3.2. "Дүүргийн Тамгын газраас хүлээлгэн өгсөн өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих хяналтыг зохион байгуулж, эд хөрөнгийн тооллогыг жилдээ явуулж, түүний үнэн зөвийг болон өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалт, ашиглалтын байдлыг Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын өмнө бүрэн хариуцна" заалтыг хэрэгжүүлээгүй, хөрөнгийн тооллого хийгээгүй тооллогын баримт үйлдээгүй, чанар байдлыг тодорхойлоогүй;
- Гэрээний 1.3 "Энэхүү гэрээний хавсралтад заагдсан орон нутгийн төрийн эзэмшлийн эд хөрөнгийн бүрэн бүтэн байдал, ашиглалт хамгаалалтын найдвартай ажиллагааг хангах хүрээнд цэвэрлэгээ, үйлчилгээг хариуцан гүйцэтгэж засвар арчлалтыг тогтмол хийнэ" гэж заасан боловч төрийн эзэмшлийн эд хөрөнгийг актаар хүлээж аваагүй зэрэг алдаа дутагдал байгаагаас гадна гэрээнд тусгагдаагүй ажил үйлчилгээ хийж гүйцэтгэн санхүүжилт авсан зэрэг зөрчлүүд илэрлээ.

Иймд гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтэд хийсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг дахин гаргахгүй байхад анхаарч ажиллах дараах **ЗӨВЛӨМЖ** хүргүүлж байна.

1. Дүүргийн Тамгын газраас хүлээлгэн өгсөн өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих хяналтыг зохион байгуулж, эд хөрөнгийн тооллогыг жилдээ явуулах;

2. Хүлээж авсан 83 байршлын байгууламж дээрх хөрөнгийг нэг бүрчлэн актаар хүлээж авах;
3. Цаашид илэрсэн зөрчил, дутагдлыг давтан гаргахгүй байхад анхаарч нөхөн бүрдүүлэх, сайжруулахад анхаарч нэгжийн удирдлагын зүгээс санаачилгатай ажиллах;

Зөвлөмжийн дагуу зөрчил дутагдал арилгасан тайлан мэдээг 2025 оны 04 дүгээр сарын 01-ны өдрийн дотор дүүргийн Дотоод аудитын албанд албан бичгээр хариу ирүүлэхийг мэдэгдье.

Тус албанаас зөвлөмжийн дагуу хийж хэрэгжүүлсэн ажилд 2025 оны 4 дүгээр улиралд хяналт шалгалтын ажлыг зохион байгуулан ажиллах болно.



Чингэлтэй дүүргийн засаг даргын дэргэдэх дотоод аудитын алба
Удирдлага
Дарга
Маам Хоролсүрэн
2025.03.19 17:03



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ДОТООД АУДИТЫН АЛБА

Баруун сэлбийн гудамж,
1 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, 15170
Утас: (976) 7014 3050
Цахим шуудан: audit@chingeltei.gov.mn

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН БИЕИЙН
ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ ДАРГА
РОЧИРПҮРЭВ ТАНАА

2025.05.12 № 84
танай _____ -ны № _____ -т

Зөвлөмж хүргүүлэх тухай

Чингэлтэй дүүргийн Засаг даргын баталсан 2025 оны 25/13 удирдамжийн дагуу Чингэлтэй дүүргийн Биеийн тамир, спортын хорооны орлого бүрдүүлэлт, орон нутгийн төсвийн зарцуулалт, өмч хөрөнгийн ашиглалтад хяналт шалгалт хийлээ.

Тус хяналт шалгалтаар:

- Байгууллагын зорилт, чиг үүргийг үр ашиг, үр нөлөөтэй хэрэгжүүлэх шаардлагад нийцүүлэн ажлын байрны шинжилгээ, үнэлгээ хийх, албан тушаалын давхардлыг арилгах.
- Байгууллагын дүрэм шинэчлэн батлуулах /Чингэлтэй дүүргийн Засаг даргын 1994 оны Б/140 захирамжаар баталгаажсан дүрэмтэй/.
- Спорт заал, бусад заал танхим түрээслүүлэх үнэ тарифыг шинэчлэн холбогдох байгууллага /албан тушаалтан/-аар баталгаажуулах.
- Байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө байхгүй /9 төрлийн спортоор хичээллүүлэх боломжтой заал танхимтай/
- Спорт заалаар 2024 он, 2025 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийг хүртэл төвлөрүүлсэн орлого 3,014.0 мянган төгрөг байгаа бөгөөд 1 жилийн төвлөрүүлэх боломжит орлогыг спорт заалны хуваарийн сул цагаар тооцоолж үзэхэд 20 дахин нэмэгдүүлэх боломжтой.
- Нийслэлийн Иргэдийн спортын XII тэмцээний Тамирчдын хоол, ус ундааны зардлыг дасгалжуулагч руу шилжүүлж анхан шатны баримт бүрдүүлээгүй, мөнгөн дүн зөрүүтэй /бүрдүүлсэн баримт нь гүйлгээний утгатай нийцэхгүй/.
- Өмч хамгаалах байнгын зөвлөл нь холбогдох хууль, дүрэм, журмын дагуу үйл ажиллагаагаа явуулаагүй. Өмч хамгаалах зөвлөлийн ажлын төлөвлөгөө, тайлан байхгүй.
- Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 114 нэр төрлийн 101,115.9 мянган төгрөгийн хөрөнгийг ашиглах болон дахин үнэлүүлэн бодит үнэ цэнээр бүртгэх асуудлыг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх талаар арга хэмжээ авч ажиллаагүй.
- Анхан шатны баримт бүрдэл дутуу /шаардах хуудас гарын үсэггүй, Жилийн эцсийн бараа материал, үндсэн хөрөнгийн тооллогыг хийхдээ эд хариуцагчийн картыг шинэчлэн гаргаагүй, дутуу бүртгэсэн.
- Гэрээний бүртгэл хийдэггүй, дугаарладаггүй, дүгнэсэн акт үйлддэггүй, Баримт бичгийн бүрдэл дутуу, үг үсгийн алдаатай.
- Байгууллагын дотоод хяналтыг хэрэгжүүлдэггүй зэрэг зөрчлүүд илэрлээ.

Иймд орлого бүрдүүлэлт, орон нутгийн төсвийн зарцуулалтад хийсэн

хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг дахин гаргахгүй байхад анхаарч ажиллах дараах **ЗӨВЛӨМЖ** хүргүүлж байна.

1. Төсвийн тухай хуулийн 16.5.9.дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрснөөр үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтцийг батлагдсан орон тооны хязгаар, төсвийн хүрээнд шинэчлэн тогтоох.

2. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн эрх бүхий этгээдээс баталсан байх.

3. Үнэ тарифыг баталгаажуулах талаар байгууллагын дүрэмд тусгаж Дүүргийн засаг дарга, ИТХ-аар батлуулах.

4. Төсвийн тухай хуулийн 6 зүйлийн 6.2.2.жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх; Сангийн сайдын 2022 оны А/282 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам"-ын 3.4.2 үндсэн үйл ажиллагааны буюу байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэх явцад бий болдог жил бүр давтагдах шинжтэй тогтмол орлогыг төсөвт тусгахгүй орхигдуулахыг хориглоно. Заалтыг мөрдөж ажиллах

5. Байгууллагын даргын 2020.11.06 өдрийн А/77 тушаалаар батлагдсан "Спорт заалны журам"-ыг хэрэгжүүлж ажиллах

6. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална: 5.1.4. үнэн зөв байх" хуулийн 13.1.Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно заалтыг мөрдөх

7. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6.эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах; Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 65 дугаар тогтоолоор батлагдсан өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам мөрдөх

8. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дугаар тогтоолын 7.1 "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" заалт мөрдөх

9. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" заалттай нийцэхгүй Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйл.

10. Засгийн газрын 2017 оны 57 дугаар тогтоолын "Байгууллага хооронд гэрээ байгуулах журам"-ын 8.1.4, 8.3 заалттай нийцэхгүй Монгол хэлний тухай хуулийн 8.1-д заасны дагуу монгол хэлний зөв бичих дүрмийг мөрдөх.

11. Засгийн газрын 311 дүгээр тогтоолоор батлагдсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам", Нийслэлийн Засаг даргын 2023 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн Журам батлах тухай А/727 дугаар захирамжийг мөрдөх

12. Цаашид илэрсэн зөрчил, дутагдлыг давтан гаргахгүй байхад анхаарч нөхөн бүрдүүлэх, сайжруулан нэгжийн удирдлагын зүгээс санаачилгатай ажиллах

Зөвлөмжийн дагуу зөрчил дутагдал арилгасан тайлан мэдээг 2025 оны 07 дугаар сарын 9-ны өдрийн дотор дүүргийн Дотоод аудитын албанд албан бичгээр хариу ирүүлэхийг мэдэгдье.

Тус албанаас зөвлөмжийн дагуу хийж хэрэгжүүлсэн ажилд 2025 оны 4 дүгээр улиралд хяналт шалгалтын ажлыг зохион байгуулан ажиллах болно.

Хавсралт 2 хуудастай.



Чингэлтэй дүүргийн засаг даргын дэргэдэх дотоод аудитын алба
Удирдлага
Дарга
Маам Хоролсүрэн
2025.05.13 12:04



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ДОТООД АУДИТЫН АЛБА

Нийслэлийн засаг захиргааны III байр,
Ж.Самбуугийн 16 дугаар гудамж,
4 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, 15170
Утас: (976) 7014 3050
Цахим шуудан: audit@chingeltei.gov.mn

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
ТАНАА

2025.03.14 № 43
танай _____-ны № _____-т

Зөвлөмж хүргүүлэх тухай

Тус дүүргийн Засаг даргын Тохижилт үйлчилгээ ХХК-ийн захиралтай байгуулсан “Хог хаягдлын үйлчилгээ нийлүүлэх” гэрээний хүрээнд 1-6, 7-16, 20-22 дугаар хороодын айл өрх, аж ахуйн нэгж байгууллагын хог тээврийн үйлчилгээг үзүүлж, хогийн цэгт зөөж тээвэрлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

Дүүргийн Дотоод аудитын албанаас дүүргийн Засаг даргын баталсан 2025 оны 2 дугаар сарын 07-ны өдрийн 25/04 дүгээр удирдамжийн дагуу Тохижилт үйлчилгээ ХХК-ийн 2024 оны Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газартай байгуулсан 1 дүгээр бүс, 2 дугаар бүсийн “Хог хаягдлын үйлчилгээ нийлүүлэх” гэрээний биелэлт, гэрээгээр хүлээсэн үүрэг хариуцлагын биелэлт, гүйцэтгэлийн санхүүжилтийн байдалд хийсэн хяналт шалгалтаар дараах зөрчил, дутагдал илэрсэн. Үүнд:

- Гэрээнд хүчингүй болсон Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 86 дугаар тогтоолыг үндэслэсэн.
- Гэрээний 4.3 дахь хэсэг Захиалагч нь гүйцэтгэгч байгууллагын гүйцэтгэлийг шалгуур үзүүлэлтийн дагуу хагас, бүтэн жилээр дүгнэхээр заасан боловч хагас жилээр үнэлж дүгнээгүй, Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолоор батлагдсан хяналт шинжилгээ хийх журмыг баримтлан шалгуур үзүүлэлтийн хувийг тодорхойлохоор тусгасан нь 2017 онд хүчингүй болсон журмаар хувь тооцохоор заасан, хяналт шинжилгээ үнэлгээ хийгдээгүй.
- “Хог хаягдлын үйлчилгээ нийлүүлэх” гэрээний 2.1.14 дэх заалтад УБ хотын ЗАА, хөндлөнгийн хяналт тавьж буй төрийн бус байгууллага, захиалагчаас тавьсан шаардлага, өгсөн үүрэг даалгавар болон байгууллага, иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол гарсан зөрчил дутагдал, түүний шийдвэрлэлттэй холбоотой авсан арга хэмжээний талаар Захиалагчид тухай бүр тайлагнаж ажиллана. Хог хаягдлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.Хог хаягдлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд олон нийтийн хяналтыг төрийн бус байгууллага, иргэдийн бүлэг, иргэн тавина гэж заасан байх ба дүүргийн хэмжээнд ямар нэгэн

төрийн бус байгууллага ажиллаагүй.

- Дүүргийн Засаг даргын Тамгын газраас Нийслэлээс шилжин ирсэн хог тээврийн 2 автомашин, цэвэрлэгээ арчилгааны зориулалттай 3 автомашиныг Тохижилт үйлчилгээ ХХК-д актаар хүлээлгэн өгсөн ч ашиглалтын гэрээ хийгээгүй.

“Хог хаягдлын үйлчилгээ нийлүүлэх” гэрээний хүрээнд гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтэд хийсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг дахин гаргахгүй байхад анхаарч ажиллахыг дараах Зөвлөмжөөр хүргүүлж байна.

1. Гэрээний үндэслэлд Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 32/03 дугаар тогтоолоор “Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам”-ыг тэмдэглэх, дүүргийн Засаг даргын Тамгын газрын хуулийн хэлтсийн гэрээний мэргэжилтнээр хянуулж байх.

2. Гэрээний 4.3 дахь хэсэг Захиалагч нь гүйцэтгэгч байгууллагын гүйцэтгэлийг шалгуур үзүүлэлтийн дагуу хагас жил, бүтэн жилээр дүгнэхээр заасныг хэрэгжүүлэх, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг баримтлах.

3. “Хог хаягдлын үйлчилгээ нийлүүлэх” гэрээний 2.1.14 дэх заалтад УБ хотын ЗАА, хөндлөнгийн хяналт тавьж буй төрийн бус байгууллага, захиалагчаас тавьсан шаардлага, өгсөн үүрэг даалгавар болон байгууллага, иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол гарсан зөрчил дутагдал, түүний шийдвэрлэлттэй холбоотой авсан арга хэмжээний талаар Захиалагчид тухай бүр тайлагнаж ажиллана. Хог хаягдлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.Хог хаягдлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд олон нийтийн хяналтыг төрийн бус байгууллага, иргэдийн бүлэг, иргэн тавина гэснийг хэрэгжүүлж төрийн бус байгууллагыг татан оролцуулах.

4. "Хог хаягдлын олон нийтийн байцаагч ажиллуулах, мөнгөн урамшуулал олгох журам"-ыг хэрэгжүүлж дүүргийн хэмжээнд ажиллах олон нийтийн байцаагчийн тоог нэмэгдүүлэх, ажиллах нөхцөл боломжийг сайжруулах, хог хаягдлын хураамжийн төвлөрүүлэлтийг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах.

5. Дүүргийн Засаг даргын Тамгын газраас Нийслэлээс шилжин ирсэн хог тээврийн 2 автомашин, цэвэрлэгээ арчилгааны зориулалттай 3 автомашиныг ашиглах гэрээг Тохижилт үйлчилгээ ХХК-тай байгуулах.

6. Халтиргаа гулгаанаас шалтгаалан хуваарь, маршрутын дагуу хог тээвэрлэлт хийх боломжгүйгээс зарим гудамж талбайд айл өрхүүд ахуйн хог хаягдлаа эмх замбараагүй хаядаг, үүсмэл хогийн цэг бий болгодог байдлыг багасгахад анхаарч хороодын ажлын албанаас алслагдсан, авто машин хүрэх боломжгүй гудамжнуудад нэгдсэн хогийн цэг байрлуулж болох эсэх саналыг Нийслэл, дүүргээс баримталж буй бодлоготой нийцүүлэн нэгдсэн шийдвэрт хүрэхэд анхаарч ажиллах.

7. Ухаалаг хогийн сав байрлуулсан нь тухайн орчинд оршин суугч иргэдийн

хэрэгцээ шаардлагад нийцэж байгаа эсэх, дутагдалтай зүйлийн талаар судалгаа шинжилгээ хийх.

Зөвлөмжийн дагуу хийж хэрэгжүүлсэн ажлын талаар 2025 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн дотор дүүргийн Дотоод аудитын албанд албан бичгээр хариу ирүүлж хамтран ажиллана уу.

Тус албанаас шаардлагатай тохиолдолд зөвлөмжийн дагуу хийж хэрэгжүүлсэн ажилд 2025 оны 4 дүгээр улиралд хяналт шалгалтын ажлыг зохион байгуулан ажиллах болно.



Чингэлтэй дүүргийн засаг даргын дэргэдэх дотоод аудитын алба
Удирдлага
Дарга
Маам Хоролсүрэн
2025.03.18 13:01



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ДОТООД АУДИТЫН АЛБА

Нийслэлийн засаг захиргааны III байр,
Ж.Самбуугийн 16 дугаар гудамж,
4 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, 15170
Утас: (976) 7014 3050
Цахим шуудан: audit@chingeltei.gov.mn

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ТОХИЖИЛТ
ҮЙЛЧИЛГЭЭ ХХК-ИЙН ЗАХИРАЛ
Э.ГАНЧИМЭГ ТАНАА

2025.03.13 № 44
танай _____ -ны № _____ -т

Зөвлөмж хүргүүлэх тухай

Чингэлтэй дүүргийн Засаг даргатай байгуулсан ЧД2023/01-06 болон Чингэлтэй дүүргийн Тамгын газрын даргатай байгуулсан ЧД2024/01-64 “Чингэлтэй дүүргийн гол гудамж зам талбайн цэвэрлэгээ хийж гүйцэтгэх” гэрээний гэрээгээр хүлээсэн үүрэг хариуцлагын биелэлт, гүйцэтгэлийн санхүүжилтийн байдалд хяналт шалгалт хийхэд дараах зөрчил, дутагдал илэрлээ. Үүнд:

1. Стратегийн зорилтуудыг тодорхойлж, урт болон дунд хугацааны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж ажиллаагүй байна.

2. Бизнес төлөвлөгөөг бодит тооцоо, судалгаанд үндэслэн Чингэлтэй дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан боловсруулж ажиллаагүй байна.

3. Гэрээнд заасан байршил бүхий зам талбайд хийсэн цэвэрлэгээ, цэвэр байлгах, цэвэрлэх, хог, хаягдлыг цэвэрлэх, халтиргаа гулгаа арилгах гэх мэт гэрээнд заасан тус бүрдээ өөр өөр давтамжтай ажлын гүйцэтгэлийг бодитоор гаргаж баталгаажуулж хэвшээгүй байна.

4. Гэрээний үүргийн 2.1.3 "Хариуцсан гудамж зам дагуух ААН, байгууллагад орчны 50 хүртэлх метр нийтийн эзэмшлийн зам талбайг цэвэрлэх талаарх эрх зүйн шийдвэрийг **сурталчлах, шаардлага** тавьж ажиллана; мөн "2.1.7 "Хариуцсан гудамж, зам дагуух ногоон байгууламжийн цэвэрлэгээ, авто болон явган замын цас, хог цэвэрлэгээ, автобусны буудлын цэвэрлэгээ, авто зогсоол, карманы цэвэрлэгээ, хогийн сав, хайс хашлагийн угаалга цэвэрлэгээ [**сард 2 удаа**/ хийж гүйцэтгэнэ" заалтуудын хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллаагүй байна.

“ Чингэлтэй дүүргийн гол гудамж зам талбайн цэвэрлэгээ хийж гүйцэтгэх ” гэрээний хүрээнд гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтэд хийсэн хяналт

шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг дахин гаргахгүй байхад анхаарч ажиллахыг дараах **ЗӨВЛӨМЖ** хүргүүлж байна.

1. Стратегийн зорилтуудыг тодорхойлж, урт болон дунд хугацааны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөг боловсруулан баталж хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.

2. Бизнес төлөвлөгөөг бодит тооцоо, судалгаанд үндэслэн Чингэлтэй дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан боловсруулж батлах.

3. Гэрээнд заасан байршил бүхий зам талбайд хийсэн цэвэрлэгээ, цэвэр байлгах, цэвэрлэх, хог, хаягдлыг цэвэрлэх, халтиргаа гулгаа арилгах гэх мэт гэрээнд заасан тус бүрдээ өөр өөр давтамжтай ажлын гүйцэтгэлийг бодитоор гаргаж баталгаажуулж хэвших.

4. Гэрээний үүргийн 2.1.3 "Хариуцсан гудамж зам дагуух ААН, байгууллагад орчны 50 хүртэлх метр нийтийн эзэмшлийн зам талбайг цэвэрлэх талаарх эрх зүйн шийдвэрийг сурталчлах, шаардлага тавьж ажиллана ", 2.1.7 "Хариуцсан гудамж, зам дагуух ногоон байгууламжийн цэвэрлэгээ, авто болон явган замын цас, хог цэвэрлэгээ, автобусны буудлын цэвэрлэгээ, авто зогсоол, карманы цэвэрлэгээ, хогийн сав, хайс хашлагийн угаалга цэвэрлэгээ [сард 2 удаа/ хийж гүйцэтгэнэ" заалтуудын хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах.

Зөвлөмжийн дагуу зөрчил дутагдал арилгасан талаар 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Дотоод аудитын албанд албан бичгээр хариу ирүүлэхийг мэдэгдье.



Чингэлтэй дүүргийн засаг даргын дэргэдэх дотоод аудитын алба
Удирдлага
Дарга
Маам Хоролсүрэн
2025.03.18 13:46